



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/45

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит
ЕБС-ийн сурагчдын сорил тэмцээн
зохион байгуулах тухай

Монгол Улсын "Биеийн тамир, спортын тухай" хууль, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 43 дугаар тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшинг үнэлж дүгнэх "Сорил" тэмцээнийг 2014 оны 09 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсугай.

2. Сорил тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 4.430.000 /дөрвөн сая дөрвөн зуун гучин мянга/ төгрөгийг нийслэлийн орон нутгийн төсвийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн нийтийг хамарсан арга хэмжээний зардлаас гаргахыг нягтлан бодогч О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.

4. Тэмцээний бэлтгэл ажлыг урьдчилан хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг ахлах мэргэжилтэн А.Болдмаад даалгасугай.

ДАРГА  Ж.ГАНБОЛД

10
09
2014

1150500105